

## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

### “БУЛГАН МЭЭЖ” ОНӨХХК –НИЙ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БУА/2020/05-ГА

**БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТ  
БОЛОН БУСАД ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ӨГСӨН  
ҮҮРЭГ, ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ ХАНГАЛТГҮЙ,  
ДОТООД ХЯНАЛТ СУЛАРСАН БАЙНА.**

---

БУЛГАН АЙМАГ 2020 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр  
Утас: 70342580 Цахим хаяг: [Ankhubayard@audit.gov.mn](mailto:Ankhubayard@audit.gov.mn)  
Аудитын менежер Ж.Энхцоодол  
Утас: 70342716 Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)  
Ахлах аудитор П.Мөнхтуяа  
Утас: 70342716 Цахим хаяг: [MonkhtuyaP@audit.gov.mn](mailto:MonkhtuyaP@audit.gov.mn)  
Аудитор Б.Энхтөр  
Утас: 70342716 Цахим хаяг: [Enkhturb@audit.gov.mn](mailto:Enkhturb@audit.gov.mn)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой  
мэдээллийг дараах хаягаар авна уу.  
Цахим хуудас [www.audit.mn](http://www.audit.mn)

---

## АГУУЛГА

### Товчилсон үгийн тайлбар.....

Хүснэгтийн товъёг.....

### Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....

### **БҮЛЭГ А. “Булган мээж” ОНӨХХК-ий төлөвлөлт үр нөлөөтэй байна**.....7

#### **А.1. “Булган мээж” ОНӨХХК нь тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг төлөвлөж ТУЗ-аар батлуулан ажиллажээ**.....7

А.1.1. “Булган мээж” ОНӨХХК нь тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг төлөвлөж ТУЗ-аар батлуулж ажилласан байна.....7

А.1.2. Байгууллагын зорилго, зорилтын дагуу ажилласан байна.....7

А.1.3. Сумын ИТХ-аар байгууллагын дүрмийг батлуулан ажиллаж байна.....7

А.1.4. Бүтэц орон тооны хувьд оновчтой батлуулж ажилласан байна.....7

#### **А.2 Орлогын бүрдүүлэлт, ХАА-ны төлөвлөлт үр нөлөөтэй байгаа ч худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн 11 хувь нь хэрэгжсэн байна**.....7

А.2.1. “Булган мээж” ОНӨХХК-ийн 2019 оны орлогын бүрдүүлэлтийг 4143.7, 38.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөн батлуулжээ.....8

А.2.2. Хөрөнгийн худалдан авах төлөвлөгөө батлуулж ажилласан ч батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлэн хөрөнгө бэлтгэсэн байна. ....8

#### **Б. “Булган мээж” ОНӨХХК-ийн санхүүгийн төлөвлөгөөний зарцуулалт үр дүн бага, байгууллагын даргын машины шатахууны зардлаас зөвхөн дотор үйлчилгээнд жилд дунджаар 10446.9 мянган төгрөг зарцуулсан байна**.....9

##### **Б.1. Санхүүгийн төлөвлөгөөг батлуулж ажилласан орлого давсан үзүүлэлтэй байгаа ч зарим орлогууд 37.6 сая төгрөгөөр тасарсан байна**.....9

Б.1.1. Жилийн орлого, зарлагыг төлөвлөхдөө орлогын үзүүлэлт, зардлын төрөл тус бүрээр нь төлөвлөн батлуулжээ.....9

Б.1.2. Санхүүгийн төлөвлөгөөний дагуу зарцуулалт хийгдсэн ч зарим зардлууд хэтэрсэн үзүүлэлтэй, анхан шатны баримтын бүрдэлт дутуу, зардал илүү шилжүүлсэн зөрчлүүдэд 2.3 сая төгрөгийн төлбөрийн акт бичлээ.....9

Б.1.3. Жилийн эцсийн санхүүгийн тайлан, мэдээ, тайланг үнэн зөв хугацаанд нь мэдээлж ажилласан байна.....10

Б.1.4. Авлага өглөгийг үнэн зөв тайлагнаж, харилцагч байгууллага иргэдтэй тооцоо нийлж баталгаажуулж ажилласан ч сүүлийн 2 жилийн авлагыг барагдуулж ажиллаагүй байна.....10

Б.1.5. Шинээр худалдан авалт хийсэн 1360.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тайланд орлого авч бүртгээгүй байна.....10

##### **Б.2. ХАА-г хууль журмын дагуу зохион байгуулагдсан ч барилга байгууламжийн ажил удаашралтай, хугацаа хэтэрсэн байна**.....

Б.2.1. Тус байгууллага нь 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмж тусгаж батлуулаагүй ажлын гэрээг гүйцэтгэгчтэй байгуулан ажиллажээ.....11

Б.2.2. Гүйцэтгэгч тухайн ажлыг гэрээний хугацаанд дуусгаагүй, хугацаа хэтэрсэн одоог хүртэл ашиглалтад ороогүй байна.....11

Б.2.3. Гүйцэтгэгчид гэрээний дагуу санхүүжилтийг олгож ажиллажээ.....11

##### **Б.3. Дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлж ажилласан ч гарсан алдаа зөрчлөөс үзэхэд дотоод хяналт сул гэж дүгнэгдэж байна**.....11

Б.3.1. ТУЗ-ын гишүүдийг сонгож ажилласан байна.....11-12

Б.3.2. Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.....12

Б.3.3. Байгууллагын жилийн үйл ажиллагааны тайланг тайлагнасан боловч аймгийн ИТХ тайланд дүгнэлт өгөөгүй, санал солилцсон тухайг хурлын тэмдэглэлээр баталгаажуулан ажиллажээ.....12

**ДҮГНЭЛТ.....13**

**ЗӨВЛӨМЖ.....13-14**

**МЭДЭГДЭЛ.....14**

### Товчилсон үгийн тайлбар

|             |                                                                               |
|-------------|-------------------------------------------------------------------------------|
| ТТХ         | Төсвийн тухай хууль                                                           |
| ИТХТ        | Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол                                         |
| ТБОНӨХБАҮХА | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах |
| ТБОНӨТХ     | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль                                  |
| ААНҮАТЗТХ   | Аж ахуй нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль                |
| КТХ         | Компаний тухай хууль                                                          |
| ХХК         | Хариуцлагатай хувьцаат компани                                                |
|             |                                                                               |

### Хүснэгтийн товъёг

| №         | Тайлбар          | Хуудасны<br>дугаар |
|-----------|------------------|--------------------|
| Хүснэгт 1 | Орлогын үзүүлэлт | 8                  |
| Хүснэгт 2 |                  |                    |

### Зургийн товъёг

| №       | Тайлбар                  | Хуудасны<br>дугаар |
|---------|--------------------------|--------------------|
| Зураг 1 | Алвага өглөгийн үзүүлэлт | 10                 |
| Зураг 2 |                          |                    |

|                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
|-------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
| <b>Аудитын зорилт</b>                     | <p><b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b></p> <p>Аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “ОНӨААТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.</p> <p>Аймгийн ОНӨААТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж дүгнэлт гарган зөвлөмж бловсруулж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.</p> <p>Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- ОНӨААТҮГ-ын ажлын төлөвлөлт үр нөлөөтэй байгаа эсэх.</li> <li>- ОНӨААТҮГ-ын санхүүгийн төлөвлөгөөний зарцуулалт үр дүнтэй зарцуулагдсан эсэх.</li> </ul> |
| <b>Аудитын хамарсан хүрээ</b>             | <p>Аудитад аймгийн ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий бусад байгууллага, аймаг сумын Засаг дарга, түүний харьяа байгууллага, гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулна.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| <b>Аудитын хязгаарлалт</b>                | <p>.....</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| <b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b> | <p>Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, захиалагч гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэл, хяналт, санхүүжилтийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийх горимыг хэрэгжүүлэх, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.</p> <p>Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор П.Мөнхтуяа, аудитор Б.Энхтөр нар хийж гүйцэтгэлээ.</p>                                                                                  |
| <b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b>       | <p>Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр хүртэл ажлын 47 хоногт хийж аудитыг үе шатны хяналтаар хянуулж аудитын тайлан, нотлох баримтыг бэлтгэн ажиллалаа.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| <b>Хүндрэл бэрхшээл</b>                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |

**А. “Булган мээж” ОНӨХХК-ий төлөвлөлт үр нөлөөтэй байна.**

**А.1. “Булган мээж” ОНӨХХК нь тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөгөөр 38.8 сая төгрөгийн ашигтай ажиллагаар батлуулжээ.**

А.1.1. “Булган мээж” ОНӨХХК нь тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг төлөвлөж ТУЗ-аар батлуулж ажилласан байна.

Тус газар нь 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг ТУЗ-ын 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 05 тоот тогтоолын хавсралтаар батлуулж ажилласан байна.

Уг тогтоолоор орлогын төлөвлөгөөг аж ахуйн нэгж, хүн ам, орон сууц, дотоод эргэлт, суурь хураамж гэсэн 5 үзүүлэлтээр ШХЦУ-ын /шугам хоолойн цэвэр ус/ орлогыг 368.0, КНС-ын /шугам хоолойн бохир ус/ орлогыг 181.8, тээвэрлэн түгээх усны орлогыг 26.4, дулаан үйлдвэрлэлийн орлогыг 3567.3 буюу нийт 4143.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж ажиллагаар үйл ажиллагааны зардлыг 4104.9, удирдлагын зардлыг 335.0, нийт 4439.9 сая төгрөгөөр тооцоолж нийт ашгийг 38.8 сая төгрөгөөр төлөвлөн батлуулжээ.

**А.1.2. Байгууллагын зорилго, зорилтын дагуу ажилласан байна.**

Тус байгууллага нь 2019 онд иргэд байгууллагуудыг эрүүл ахуй стандарт хангасан цэвэр ус түгээн нийлүүлж хэрэглэгчдийг найдвартай дулаан эрчим хүчээр ханган ажиллах зорилт тавьсан байна.

Дээрх зорилтын хүрээнд ус түгээх, сувагжуулалт, дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулж тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг хийж ажилчдыг мэргэшүүлж чадваржуулахаар сургалтад хамрагдуулж Барилгын хөгжлийн төв, ШУТИС-тай хамтран инженер, техникч, дулаан, цэвэр, бохир усны засварчдад мэргэжил олгох, сургалтыг "Барилгын гадна болон дотор ус хангамж бохир ус зайлуулах системийн угсралт, цэвэрлэх байгууламжийн ашиглалт засвар үйлчилгээ", "Дулаан хангамж, халаалтын систем, угсралтын схем, дулааны эх үүсвэртэй холбох технологи, стандарт зураг схем ашиглалт засвар үйлчилгээ зэрэг сэдвээр сургалт авч ажилласан байна.

Мөн цаашид анхаарч ажиллах асуудлуудыг дүгнэн гаргажээ.

Үүнд: Усны алдагдлыг бууруулж зөөврийн ус түгээх байруудыг дэвшилтэд ухаалаг төхөөрөмжтэй болгох, бохир ус татан зайлуулах станцыг сүүлийн үеийн технологийн дагуу бохир усыг цэвэрлэх байгууламжтай болгох, гэр хорооллын айл өрхийн хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд нэвчилтгүй нүхэн жорлон төслийг хэрэгжүүлэх, мөн уурын зуухны хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг цаашид хэрэгжүүлж ажиллагаар зорилт дэвшүүлж ажиллажээ.

**А.1.3. Аймгийн ИТХ-аар байгууллагын дүрмийг батлуулан ажиллаж байна.**

“Булган мээж” ОНӨХХК нь байгууллагын дүрмийг аймгийн ИТХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 126 тоот тогтоолын хавсралтаар 13 сэдвийн 162 асуудлын хүрээнд баталж дотоод дүрмийг мөрдөн ажиллаж байна.

Мөн тус газар нь үйлдвэрчний хороотой хамтын гэрээ байгуулан байгууллагын дотоод асуудал, ажилчдын цалин, урамшуулал, амралт, чөлөө, хөдөлмөр хамгаалалт, ажилтанд олгох нийгмийн хөнгөлөлт зэргийг олгохдоо хамтын гэрээг үндэслэн олгохоор гэрээ байгуулан ажиллажээ.

**А.1.4. Бүтэц орон тооны хувьд оновчтой батлуулж ажилласан байна.**

ТУЗ-ийн 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 05 тоот тогтоолоор бүтэц орон тоог ус сувгийн, дулаан, захиргаа аж ахуй, санхүүгийн гэсэн бүтэц зохион байгуулалтайгаар үндсэн ажилчдын орон тоог 79, гэрээт ажилчдын орон тоог 104 нийт 183 ажилтантайгаар ажиллагаар батлуулсан байна.

Гүйцэтгэлээр үндсэн ажилтан 79, гэрээт ажилтан 58 нийт 137 ажилтантайгаар буюу батлагдсан орон тооноос 46 ажилтнаар бага орон тоогоор үйл ажиллагаагаа явуулжээ.

**А.2. Орлогын бүрдүүлэлт, ХАА-ны төлөвлөлт үр нөлөөтэй байгаа ч худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн 11 хувь нь хэрэгжсэн байна.**

**А.2.1. “Булган мээж” ОНӨХХК-ий 2019 оны орлогын бүрдүүлэлтийг 4143.7 сая төгрөгөөр төлөвлөж батлуулжээ.**

“Булган мээж” ОНӨХХК нь 2019 оны үйл ажиллагааны жилийн орлогыг ШХУЦ-ийн орлогыг 368.1, тээвэр усны орлогыг 26.5, КНС-ийн /бохир/ орлогыг 181.8, дулааны орлогыг 3567.3 сая төгрөгөөр тус тус тооцож нийт 4143.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж 38.7 сая төгрөгийн ашигтай ажиллахаар батлуулсан ажилласан байна.

Жилийн орлогын бүрдүүлэлтийг орлогын үзүүлэлт тус бүрээр аж ахуй нэгж байгууллага, дотоод эргэлт, орон сууц, хүн ам, суурь хураамж гэж ангилан орлогыг тооцоолон төлөвлөжээ.

Үүнийг графикаар харуулбал:



Графикаас үзэхэд аж ахуй нэгж, байгууллагын орлого 92, хүн амын үзүүлэлтийн орлого 1, орон сууц 3, дотоод эргэлт 3 хувийг тус тус эзэлж байгаа нь орлогын ихэнх хувийг аж ахуй нэгж байгууллагуудын орлого бүрдүүлж байгаагаар илэрхийлэгдэж байна.

**А.2.2. Хөрөнгийн худалдан авах төлөвлөгөө батлуулж ажилласан ч батлагдсан төлөвлөгөөний зардлаас 650.0 мянган төгрөг хэтрүүлэн хөрөнгө бэлтгэсэн байна.**

“Булган мээж” ОНӨХХК нь аймгийн ИТХ-ын 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 36 тоот тогтоолоор 10 төрлийн хөрөнгө бэлтгэх болон засвар хийх үйл ажиллагаанд нийт 227.5 сая төгрөгийг зарцуулахаар хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулан ажиллаж гүйцэтгэлээр 3 хөрөнгө оруулалтын 24.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэх ажил хийгдэж 203.0 сая төгрөгийн ажил хийгдээгүйг төсөв хөрөнгөтэй холбон үзэж байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 16 тоот аймгийн Онцгой комиссын “Бэлтгэл, бэлэн байдлыг хангах тухай” албан бичгийн дагуу нэмэлт тоног төхөөрөмж суурилуулах болж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 80.1 сая төгрөгийн хөрөнгийн худалдан авалт буюу хөрөнгө оруулалтын ажил хийгджээ.

ТУЗ-ийн 2019 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 21 тоот хөрөнгө бэлтгэх тухай тогтоолд 14.5 сая төгрөгийн төсөвт багтаан мотор, кроп худалдан авахаар шийдвэр гарсан боловч 650.0 мянган төгрөг хэтрүүлэн нийт 15.1 сая төгрөгөөр, мөн 49.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжүүдийн худалдан авалт хийсэн нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 24.2.<sup>1</sup> дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Цаашид батлагдсан төсөвт багтаан, тогтоол шийдвэрийг үндэслэж ажиллах шаардлагатай.

<sup>1</sup> Төрийн байгууллагаас бусад төрийн өмчит хуулийн этгээд батлагдсан зардлын хэмжээнд багтаан шаардлагатай хөрөнгийг өөрөө худалдаж авах ба төрөөс түүнд хариу төлбөргүйгээр олгож болно

**Б. “Булган мээж” ОНӨХХК-ий санхүүгийн төлөвлөгөөний зарцуулалт үр дүн бага, байгууллагын даргын машины шатахууны зардлаас зөвхөн дотор үйлчилгээнд жилд дунджаар 10.4 сая төгрөг зарцуулсан байна.**

**Б.1 Санхүүгийн төлөвлөгөөг батлуулж ажилласан ч орлого давсан үзүүлэлтэй байгаа боловч зарим орлогууд 37.6 сая төгрөгөөр тасарсан байна.**

Б.1.1 Жилийн орлого, зарлагыг төлөвлөхдөө орлогын үзүүлэлт, зардлын төрөл тус бүрээр нь төлөвлөн батлуулжээ.

“Булган мээж” ОНӨХХК нь 2019 оны үйл ажиллагааны жилийн орлогыг нийт 4143.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3866.1 сая төгрөгийн зардал гаргаж, ажиллагсдын нийгмийн арга хэмжээний зардалд 226.9 сая төгрөгийг зарцуулж, ААНОАТ болон ногдол ашгийг 11.9 сая төгрөгийг төвлөрүүлж 38.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөн батлуулж удирдлагын зардлыг 335.0, үйл ажиллагааны зардлыг 3531.1 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн нь үр нөлөөтэй төлөвлөсөн гэж үзэж байна.

Тухайн жилд гүйцэтгэлээр үйл ажиллагааны борлуулалтын орлогыг 4183.7 сая төгрөгөөр бүрдүүлж төлөвлөснөөс 40.0 сая төгрөгөөр илүү орлого бүрдүүлж ажилласан боловч зарим орлогууд тасарсан үзүүлэлтэй гарчээ.

Үүнд: ААН-ийн орлого 25.8, сувагжуулалтын хэсгийн орлого 25.6 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн боловч дулаан 36.5, ШХУ-ын хэсэг 23.3, тээвэр усны хэсэг 2.5, орон сууц цэвэр усны орлого 11.6, дотоод эргэлтийн орлого 37.6 сая төгрөгөөр тасарсан нь хүн амын хэрэглээ багассан, ухаалаг худаг нэмж суурилсантай холбоотой үзэж байна.

Цаашид тасарсан орлогуудын шалтгааныг тогтоож орлого нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

**Б.1.2 Санхүүгийн төлөвлөгөөний дагуу зарцуулалт хийгдсэн ч зарим зардлууд хэтэрсэн үзүүлэлтэй, анхан шатны баримтын бүрдэлт дутуу, зардал илүү шилжүүлсэн зөрчлүүдэд 2.3 сая төгрөгийн төлбөрийн акт бичлээ.**

Тус байгууллага нь 2019 оны үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөг 3866.1 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 4394.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Зардлын гүйцэтгэлийг авч үзвэл жилийн эцсийн санхүүгийн тайлан болон санхүүгийн шинжилгээгээр 2019 оны байдлаар нийт 4394.8 сая төгрөгийг удирдлагын болон үйл ажиллагааны зардалд зарцуулсан нь төлөвлөсөн зардлаас 528.7 сая төгрөгийн зардал илүү зарцуулсан нь томилолтын зардал 2.9, элэгдлийн зардал 124.8 сая төгрөгөөр хэтэрч, үлдэгдэл 401.0 сая төгрөгийн зардлын хэтрэлтийг дулааны станцтай сарын дулааны орлогоос 60 хувийг нь шилжүүлэхээр гэрээ хийж ажилласантай холбоотой байна.

Тус байгууллагын зардлын зарцуулалтыг түүвэрлэн үзэхэд томилолтын зардлын хоногийг илүү тооцсон, анхан шатны баримтын бүрдэлт дутуу байхад 817.5 мянган төгрөг, байгууллагын захиралд тушаал шийдвэргүй үр дүнгийн урамшуулал 696.4, түлээний хөнгөлөлт 161.1 мянган төгрөгийг тус тус олгосон, зуслангийн шовгорын 360.0, 290.0 мянган төгрөгийн нүүрсийг орлогод аваагүй тус тус илүү шилжүүлсэн нийт 2325.0 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс аудитын явцад 857.5 мянган төгрөгийг барагдуулж 1467.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, цалин, томилолтын урьдчилгааг суутган тооцохдоо материалаар болон томилолт бусад тэтгэмжийн зардлаас 4134.7 мянган төгрөгийг суутган тооцсон, дотор үйлчилгээнд даргын албаны машин жилд дунджаар 13696 км явж 10447.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан зөрчлүүдэд зөвлөмж өглөө.

Цаашид үйл ажиллагаанд гарах зардлыг зориулалт зардал тус бүрээр нь тайлагнаж, дотор үйлчилгээнд явах автомашины шатахуун зарцуулалтыг багасгах шаардлагатай байна.

**Б.1.3 Жилийн эцсийн санхүүгийн тайлан, мэдээ, тайланг үнэн зөв хугацаанд нь мэдээлж ажилласан байна.**


“Булган мээж” ОНӨХХК нь 2019 онд жилийн эцсийн байдлаар эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг 1124.7, эргэлтийн бус хөрөнгийн үлдэгдлийг 6837.3 нийт хөрөнгийн дүнг 7962.0 сая төгрөгөөр тайлагнаж хагас, бүтэн жилээр хуулийн хугацаанд санхүүгийн тайлан мэдээг мэдээлж эргэлтийн хөрөнгө 294.9 сая төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгө 717.3 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлтэй гарч байна.

Тухайн жилд өөрийн хөрөнгөөр болон хөрөнгө оруулалтаар нийт 213.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэн ажиллажээ.

**Б.1.4. Авлага өглөгийг үнэн зөв тайлагнаж, харилцагч байгууллага иргэдтэй тооцоо нийлж баталгаажуулж ажилласан ч сүүлийн 2 жилийн авлагыг барагдуулж ажиллаагүй байна.**

“Булган мээж” ОНӨХХК нь 2019 онд 147.2 сая төгрөгийн авлагыг барагдуулж жилийн эцэст 64.5, 97.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг 4.5 сая төгрөгөөр бууруулж 53.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Авлага, өглөгийг графикаар харуулбал:



Графикаас харахад нийт авлагын 83 хувийг аж ахуйн нэгжийн, 18 хувийг орон сууцны авлагууд эзэлж байна.

Тус авлагуудаас 2017-2018 онуудын дулааны 21.7 сая төгрөгийг орлогыг одоог хүртэл барагдуулж ажиллаагүй зөрчил илэрсэн тул албан шаардлага бичлээ.

**Б.1.5. Шинээр худалдан авалт хийсэн 1360.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тайланд орлого авч бүртгээгүй байна.**

“Булган мээж” ОНӨХХК 2019 онын худалдан авах ажиллагаа, хөрөнгө бэлтгэх төлөвлөгөөнд 227.5 сая төгрөгийн хөрөнгийг батлуулж гүйцэтгэлээр 213.3 сая төгрөгийн хөрөнгийг бэлтгэсэн боловч үндсэн хөрөнгийн тайланд цахилгаан удирдлагын 1360.0 мянган төгрөгийн самбар, шовгорын газрыг тус тус орлого авч тайлагнаагүй зөрчилд албан шаардлага бичлээ.

Ашиглалтад байгаа үндсэн хөрөнгөөс хойшид ашиглах боломжгүй хэрэгцээ шаардлага хангахгүй болсон 54 нэр төрлийн 14.4 сая төгрөгийг хөрөнгийг аймгийн ИТХ-ын 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 14 тоот тогтоол шийдвэрийн дагуу данс бүртгэлээс хасаж тайлагнажээ.

**Б.2. ХАА-г хууль журмын дагуу зохион байгуулагдсан ч барилга байгууламжийн ажил удаашралтай, хугацаа хэтэрсэн байна.**

**Б.2.1. Тус байгууллага нь 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмж тусгаж батлуулаагүй ажлын гэрээг гүйцэтгэгчтэй байгуулан ажиллажээ.**

“Булган мээж” ОӨНХХК нь 2019 онд аж ахуйн нэгж, төсөвт байгууллага, иргэдтэй дулаан, цэвэр усны орлогын, нүүрсний гэрээг тус бүр хийж гэрээнд тусгагдсаны дагуу төлбөр тооцоог тооцон ажилласан боловч 2018 онд батлуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 2019 онд барилга байгууламжийн ажил эхлүүлэхээр гэрээ хийж ажиллажээ.

Тухайлбал: Тус газар нь 2018 онд 10 машины сендивчэн граж, аваарын цехийн барилга шинээр барихаар төлөвлөгөөнд тусгаж батлуулсан боловч 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмж тусган батлуулаагүй, 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр “Сувдан элс” ХХК-тай гэрээ байгуулсан байна.

Тухайн жилд нийт 15180 тн нүүрсний гэрээг “Баян-тээг” ХХК, “Техно перспектив” ХХК-тай нүүрс нийлүүлэгчээр, тээвэрлэгчээр “Дэл агт” ХХК-тай гэрээг 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр, аймгийн ИТХ-хурлын 2019 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн 63 тоот тогтоолыг үндэслэн “Энержи плас” ХХК-тай дулаан ашигласны орлогоос 60 хувь буюу 436.3 сая төгрөгийг шилжүүлж ажиллахаар 2019 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн тус тус гэрээ байгуулан ажиллажээ.

### **Б.2.2. Гүйцэтгэгч тухайн ажлыг гэрээний хугацаанд дуусгаагүй, хугацаа хэтэрсэн одоог хүртэл ашиглалтад ороогүй байна.**

“Булган мээж” ОӨНХХК нь 2019 оны байдлаар 79.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 машины сендивчэн граж, аваарын цехийн барилга шинээр барих ажлын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж гүйцэтгэгчээр “Сувдан элс” ХХК-иар гүйцэтгүүлэхээр 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч одоо хүртэл ашиглалтад оруулаагүй, гэрээний ерөнхий нөхцөлд тусгагдсаны дагуу алданги тооцож гэрээ дүгнэж ажиллаагүй, тус барилгын ажилд байгууллагын үйл ажиллагааны шатахууны зардлаас 688.9 мянган төгрөг зарцуулсан зөрчлүүд илэрч уг зөрчилд зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

Цаашид төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх, хугацааг нарийн тооцож гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай байна.

### **Б.2.3. Гүйцэтгэгчид гэрээний дагуу санхүүжилтийг олгож ажиллажээ.**

“Булган мээж” ОӨНХХК нь “Сувдан элс” ХХК-иар гүйцэтгүүлж байгаа барилга байгууламжийн ажлын санхүүжилтийг 75.0, “Баянтээг” ХХК-д 5350 тн нүүрсний үнэ 155.1, “Техно перспектив” ХХК-д 2426 тн нүүрсний үнэ 76.2, “Энержи плас” ХХК-д дулааны орлогын 1259.9 сая төгрөгийг тус тус шилжүүлэн ажилласан байна.

“Сувдан элс” ХХК-д 75.0 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 94 хувийг олгосон нь санхүүжилтийн хуваарь хийгээгүй гэрээ байгуулсан, ажлын гүйцэтгэлийг дүгнэж санхүүжилт олгоогүй нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 20.1.7<sup>2</sup>, байгууллагын дүрмийн 6.1.2<sup>3</sup>, 12.1<sup>4</sup> гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлүүд илэрлээ.

### **Б.3. Дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлж ажилласан ч гарсан алдаа зөрчлөөс үзэхэд дотоод хяналт сул гэж дүгнэгдэж байна.**

#### **Б.3.1. ТУЗ-ийн гишүүдийг сонгож ажилласан байна.**

“Булган Мээж” ОӨНХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь аймгийн ИТХ-ын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор 9 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн томилогдсон байна.

ТУЗ нь 2019 онд 14 удаа хуралдаж нийт 32 асуудал хэлэлцэж, 9 тогтоол гарган хэрэгжилтийг хангаж, ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороог 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, ажиллах журмыг боловсруулан батлуулж ажилласан боловч аудитын хорооны гишүүд компаний үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан ажлын тайланг баримтжуулаагүй, мөн ТУЗ-ийн дарга, гишүүд нь 2019 оны хагас бүтэн жилийн үйл

<sup>2</sup> “Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах

<sup>3</sup> компаний жилийн төлөвлөгөөг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих

<sup>4</sup> Санхүүгийн бүртгэлийн үйл ажиллагаа нь НББ-ийн тухай хуулийн дагуу явагдана

ажиллагааны тайланг тайлагнаагүй нь “Булган Мээж” ОНӨХХК-ий дүрмийн 5.6.2<sup>5</sup> дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлүүд илэрсэн.

Цаашид ТУЗ болон аудитын хороод компаний үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан ажлын тайланг баримтжуулан дотоод хяналтаа сайжруулах шаардлагатай байна.

### **Б.3.2 Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.**

“Булган мээж” ОНӨХХК нь 2019 онд дотооддоо хяналт орлого бүрдүүлэлт, санхүүгийн зарцуулалт, үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон хяналтын 2 шалгалтыг явуулж уг шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгахаар зөвлөмж үүрэг даалгавар өгч ажиллажээ. Үүнд:

- Орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ашигт ажиллагааг сайжруулах, үнэ тарифын шатлалыг цэгцлэх
- Усны зүй бус хэрэглээг таслан зогсоох, ус балансжуулах
- ТУЗ-ийн баталсан үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөлтийг барьж ажиллах
- Инженер техник, боловсон хүчний бодлогын бичиг баримттай болох
- Зардал хэмнэх бололцоог хайх эрэлхийлэх /түлш, тээвэр, ус, шатахуун/
- Хэрэглэгчид руу чиглэсэн бодлого барих, зар сурталчилгааны ажлыг өргөжүүлэх, хэвшүүлэх
- Эрчим Хүчний Сайдын тушаалыг барьж халаалтын гэрээг 8 сараар мөрдөж байхаар зөвлөгөө өгсөн байна.

Мөн аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтсээс 2016-2019 оны санхүүгийн баримтад төлөвлөгөөт шалгалтууд орж шалгалтаар ажилчдын нийгмийн даатгалын шимтгэл дутуу тооцсон буюу хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийн алдангийн нийт 8996.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдсаныг хугацаанд нь барагдуулж ажилласан нь зарцуулалтын тооцооны алдаанаас төлөвлөгдөөгүй зардал үүсэж байна.

Аймгаас болон дотооддоо явуулсан хяналт шалгалтын дүнгээс үзэхэд ашиг орлогыг дээшлүүлэх тал дээр ажил зохион байгуулж ажиллах, мөн санхүүгийн үйл ажиллагааны зарцуулалтын тооцоонд дотоодын хяналтыг сайжруулах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

### **Б.3.3. Байгууллагын жилийн үйл ажиллагааны тайланг тайлагнасан боловч аймгийн ИТХ тайланд дүгнэлт өгөөгүй, санал солилцсон тухайг хурлын тэмдэглэлээр баталгаажуулан ажиллажээ.**

“Булган мээж” ОНӨХХК нь 2019 оны үйл ажиллагааны тайланг аймгийн ИТХ-д 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 05 тоот хуралд жилийн тайланг видео хэлбэрээр танилцуулж уг хуралд өөрийн байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулахаар, нэмж суурилуулах тоног төхөөрөмжтэй холбоотой хөрөнгө оруулалтын саналыг танилцуулж ажилласан байна.

Уг хуралдаанаар тус байгууллагын 2019 оны үйл ажиллагааны талаарх дүгнэлтийг хувиар дүгнээгүй санал солилцож ажилласан байна.

Аудитаар нийт 46236.6 мянган төгрөгийн төлбөр зөрчил илрүүлснээс аудитын явцад 857.6 мянган төгрөгийн актын төлбөрийг барагдуулж, 1467.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 29329.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 14581.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

### **ДҮГНЭЛТ:**

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

---

<sup>5</sup> “ТУЗ нь үйл ажиллагааныхаа тайланг жилд 2-оос доошгүй удаа, компани ашгийн хуваарилалтын талаарх саналыг боловсруулж дараа оны 1 дүгээр улиралд багтаан үүсгэн байгуулагчийн хурлаар хэлэлцүүлнэ”

- “Булган мээж” ОНӨХХК нь 2019 онд 4143.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж ажиллахаар нийт зардлыг 4439.9 сая төгрөгөөр төлөвлөж нийт ашгийг 38.8 сая төгрөгөөр төлөвлөн батлуулснаас 40.0 сая төгрөгийн орлого илүү бүрдүүлж ажилласан ч 653.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласнаар тайлагнасан байна.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 11 хувьтай хэрэгжсэн.
- Хөрөнгө бэлтгэх тухай тогтоол шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгө бэлтгэсэн ч батлагдсан төсвөөс 650.0 мянган төгрөгийн төсөв хэтрүүлж худалдан авалт хийсэн.
- Сүүлийн 2 буюу 2017-2018 онд үүссэн дулааны 21.7 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй.
- Гэрээгээр хийгдэж байгаа барилга байгууламжийн ажилд өөрийн үйл ажиллагааны зардлаас шатахууны 688.0 мянган төгрөгийг зарцуулсан.
- Цалин, томилолтын 4134.7 мянган төгрөгийн урьдчилгааг материалаар болон бусад тэтгэмж томилолтын зардлаас суутган тооцсон.
- Томилолтын 817.5 мянган төгрөгийн зардал олгохдоо хоног илүү тооцож, анхан шатны баримтын бүрдэлт дутуу, томилолтын болон зам зардлын он сар зөрүүтэй баримтыг үндэслэж олгосон.
- Тушаал шийдвэргүйгээр 857.5 мянган төгрөгийг түлээ, үр дүнгийн урамшуулалд олгосон.
- Албаны машинаар жилд дотор үйлчилгээнд нийт 13696 км явж дунджаар 10.4 сая төгрөгийн шатахуун зарцуулсан, жолоочийн тооцооны замын хуудсыг 836.4 мянган төгрөгөөр дутуу хөтөлсөн.
- Шинээр бэлтгэсэн 1360.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн орлогод авч тайлагнаагүй.
- ТУЗ болон аудитын хорооны гишүүд нь үйл ажиллагааны тайланг баримтжуулан ажиллаагүйгээс хагас, бүтэн жилээр үйл ажиллагааны тайланг тайлагнаж ажиллаагүй.
- Мөн ТУЗ-ын дарга, гишүүдэд урамшуулал олгохдоо ажлын үзүүлэлтийг тооцоогүй, тооцсон тухай тайлан дүгнэлт байхгүй, жилд 7.2 сая төгрөгийн урамшуулал олгосон.
- Ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллыг хийж байгаа боловч цаг хугацаанд нь шимтгэлийг тооцож шилжүүлээгүйгээс 8.9 сая төгрөгийн төлбөрийн актыг төлсөн.
- Дээрх зөрчлүүдээс үзэхэд байгууллагын төлөвлөгөөт хяналт шалгалт болон бусад хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй, дотоод хяналт суларсан гэж дүгнэж байна.

### **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:  
НЭГ. ТУЗ-ийн дарга Н.Мэндсайханд:

1. ТУЗ болон аудитын хорооны гишүүд хагас бүтэн жилээр 2 удаа үйл ажиллагааны тайланг тайлагнаж баримтжуулан ажиллах.

ХОЁР. “Булган мээж” ОНӨХХК-ий захирал Д.Очирбат, ерөнхий нягтлан бодогч А.Даваасүрэн нарт:

1. Байгууллагын үйл ажиллагааны зардлаас төлөвлөгдөөгүй зардал гаргахгүйгээр, алдагдлыг бууруулж ажиллах.
2. Батлагдсан төсөвт багтаан, тушаал шийдвэрийн дагуу хөрөнгө бэлтгэж ажиллах.
3. Худалдан авах ажиллагаагаар хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажилд байгууллагын үйл ажиллагааны зардлаас зардал гаргахгүй байх.
4. Хяналт шалгалтаар илэрсэн актын төлбөрийг буруутай этгээдээр хохирлыг барагдуулан ажиллах.

5. Байгууллагын дотор үйлчилгээнд ашиглаж байгаа автомашины шатахууны зардлыг өдөрт явах норм, км-ын дагуу ашиглах.

**МЭДЭГДЭЛ:**

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулж хэрэгжилт, үр дүнг 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хариу ирүүлэхийг мэдэгдье.

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

**АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:**

АХЛАХ АУДИТОР

П.МӨНХТУЯА

АУДИТОР

Б.ЭНХТӨР